# САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2016 оны 03 сарын 04 өдөр Дугаар 49 Улаанбаатар хот

Журам, дансны жагсаалт шинэчлэн батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, Даатгалын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2, 32 дугаар зүйлийн 32.2, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2, 19 дүгээр зүйлийн 19.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчийн санхүүгийн нэмэлт тайлангийн агуулга, маягтыг тохтоох журам"-ыг нэгдүгээр, "Даатгалын компанид мөрдөх дансны жагсаалт"-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус шинэчлэн батлсугай.

2. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан "Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчийн санхүүгийн нэмэлт тайлангийн агуулга, маягтыг тогтоох журам"-ыг батлах тухай Хорооны 2009 оны 275 дугаар тогтоол, "Даатгалын компанид мөрдөх дансны үлгэрчилсэн заавар"-ыг батлах тухай Хорооны 2012 оны 373 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

3. Шинэчлэн батлагдсан журам, дансны жагсаалтыг олон нийтэд мэдээлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ажлын алба /Ц.Нацагдорж/-нд тус тус даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ГҮЙЦЭТГЭГЧ,
ДЭД ДАРГА Э.БАТБОЛД

000093